



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2022 он 06  
сарын 10 өдөр

Дугаар 352/342

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, соёлын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг хийх болсныг үүгээр уламжилж байна.



Монгол Улсын Шадар сайд

С.АМАРСАЙХАН

000224001255



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2022 он 06 сарын 10 өдөр

Дугаар 31-2/341

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратеги, соёлын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 9 хуудастай.

Монгол Улсын Шадар сайд



С.АМАРСАЙХАН

000224001252

## **МОНГОЛ УЛСЫГ ГАДААДАД СУРТАЛЧЛАХ БОДЛОГО, СТРАТЕГИ, СОЁЛЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг баримт бичигт тусгасны дагуу Монгол үндэстний оршин тогтнох амин чухал дархлаа болох Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалах, хөгжүүлэх, дэлхийн улс орнуудтай соёлын хамтын ажиллагааг өргөжүүлж, дипломат төлөөлөл болон иргэдээрээ дамжуулан дэлхий дахинд сурталчлах, улс орныхоо гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

### **Нэг. Монгол Улсыг гадаадад сурталчлах бодлого, стратегийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлын талаар**

Олон улсын харилцаанд “зөөлөн хүч” (soft power), “ухаалаг хүч” (smart power)-ний талаарх ойлголт улам өргөн хэрэглэгдэж байна. Зөөлөн хүч нь хэл, соёл, урлаг, боловсрол, улс төрийн үзэл суртал, үнэт зүйл, гадаад бодлогын манлайллаар бусдыг татах, нөлөөллөө тогтоох, улмаар зорилгодоо хүрэх гадагш чиглэсэн бодлого байдаг бөгөөд Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололтыг олон улсад сурталчлан таниулах зорилгоор “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”<sup>1</sup>, “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг 2016-2020 онд амжилттай хэрэгжүүлсэн.

Эдгээр хөтөлбөрүүдийн үр дүнд бий болсон үндэс суурийг улам бэхжүүлж, үргэлжлүүлэх, төгөлдөржүүлэх зорилтын хүрээнд 2021-2024 онд хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн “Монгол Үндэстний үнэлэмж”, “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна.

#### **“Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн үр дүнд гадаад сурталчилгааны бодлого, үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийт хамтран үр дүнтэй хэрэгжүүлэх, харилцан уялдаа холбоотой ажиллах нөхцөл боломж бүрдсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөлийг Гадаад харилцааны сайдаар ахлуулан гадаад сурталчилгааны үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, хамтрагч байгууллага бүр өөрийн төсөв, нөөц бололцооны хүрээнд үр дүнтэй зохион байгуулсан.

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т дэлхийн улс орнуудтай соёлын харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх замаар гадаад сурталчилгааг эрчимжүүлэх, гадаад таатай орчныг бүрдүүлэх, монгол хэл, соёл, монгол судлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулахад чиглэсэн “Монгол

---

<sup>1</sup> “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2016 оны 2 дугаар тогтоолоор батлан, 2016-2020 онд хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд дэлхийн 40 гаруй улсад 740 гаруй ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна. Тухайлбал, соёл, урлагийн чиглэлээр 309, хэвлэл мэдээллийн чиглэлээр 100, Монгол судлалын чиглэлээр 69, аялал жуулчлалын чиглэлээр 122, үндэсний брэнд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах ажлын хүрээнд 84, спортын чиглэлээр 61 ажил, арга хэмжээг зохион байгуулав.

Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Зөвлөлийг Гадаад харилцааны сайдаар ахлуулан 14 яам, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.

Энэхүү цогц арга хэмжээний хүрээнд 6 зорилтыг дэвшүүлээд байна. Үүнд:

- Монгол үндэстний үнэт зүйлс, түүх, биет болон биет бус соёлын өв, уламжлалт болон орчин үеийн соёл, урлаг, оюуны болон дижитал бүтээл, спортын амжилтыг дэлхийн хэмжээнд сурталчлах;
- Монгол судлалын хүрээг тэлж, дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаалах;
- Хилийн чанадад Монголын соёл, мэдээллийн төв байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих;
- Монгол Улсын хөгжлийн ололт амжилт, мега төсөл, хөтөлбөрийг хилийн чанадад танилцуулж, хөрөнгө оруулагч, хамтран хэрэгжүүлэгч олоход дэмжлэг үзүүлэх;
- Худалдаа, эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх;
- Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 16 багц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гадаад сурталчилгааг эрчимжүүлэхэд зориулж тодорхой санхүүжилтийг 2022 оны төсөвт суулгасан бөгөөд энэ оны эхний улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- “Монголын нууц товчоо”-г болгар<sup>2</sup> болон румын хэл дээр хэвлэх;
- БНЧехУ-ын Карлын их сургуулиас 2000 оноос хойш эрхлэн гаргаж байгаа монгол судлалын “Mongolica Pragensia” эрдэм шинжилгээний сэтгүүлийг эрхлэн гаргах;
- ЮНЕСКО-ийн албан ёсны хэвлэл “World Heritage Review” сэтгүүлийн Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг баталсны 50 жилийн ойд зориулсан тусгай дугаарт Монголын тухай нийтлэл гаргах болон “Google Arts and Culture Platform”-д Монголын ЮНЕСКО-д бүртгэгдсэн 5 өвийн газар нутгийг сурталчлах арга хэмжээнүүдийг холбогдох газруудтай тохиролцон хэрэгжүүлж байна.

*Соёл урлаг, аялал жуулчлалын чиглэлээр:*

Монгол үндэстний дээл хувцсыг сурталчлан таниулах зорилгоор хилийн чанад дахь 49 дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан “Монгол хувцасны нууц товчоон” баримтат киног суугаа болон хавсран суугаа орондоо сурталчлах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулаад байна.

Түүнчлэн энэ оны 2 дугаар сард БНБолгарУ-ын Софи хотноо “Holiday&Spa International Fair”, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад “Монголын киноны өдрүүд” кино наадам, 3 дугаар сард Япон Улсын Шизүоко мужийн Яйзү хотноо “Монгол наадам” арга хэмжээ, 4 дүгээр сард Шведийн Хаант Улсын нийслэл Стокхолм хотод “Соёлын үдэш” арга хэмжээ, 5, 6 дугаар сард ХБНГУ-д Монголын морин хуурын анхны наадам болон “НордАрт” олон улсын дүрслэх урлагийн наадмыг тус тус зохион байгууллаа.

---

<sup>2</sup> Болгар хэлээр 4 дэх удаагаа хэвлэгдэж байна.

Мөн Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Морин хуурын чуулгын бүрэн хэмжээний тоглолтыг Японд, АНУ-тай дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан Морин хуурын чуулгын аялан тоглолтыг АНУ-ын 6 хотод, Үндэсний урлагийн их театрын 100 гаруй уран бүтээлчдийн тоглолт болон “Монголын соёлын өдрүүд” арга хэмжээг БНФУ-ын Парис хотноо зохион байгуулахаар ажиллаж байна.

### **“Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээний хүрээнд:**

“Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг 2016-2020 онд амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд уг хөтөлбөрийн үргэлжлэл “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг баталж, удирдан зохион байгуулах Зөвлөлийг байгуулан 2021-2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

Цогц арга хэмжээний хүрээнд дараах зорилтуудыг хангана. Үүнд:

- Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах;
- Монгол судлалын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн цахим сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, тэдний эх хэлээ суралцах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, монголчуудын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээний арга хэмжээг хамтран зохион байгуулах;
- Хилийн чанад дахь Монголын соёлын өвийг хадгалан хамгаалах, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах зэрэг болно.

Цогц арга хэмжээний хүрээнд 2022 оны эхний улиралд дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

- Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж байгаа монгол сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвийн судалгааг 1 дүгээр сард хийсэн бөгөөд одоогийн байдлаар дэлхийн 11 улсын 25 хотод нийт 44 монгол сургууль, цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжих, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Гадаад харилцааны яамнаас холбогдох төрийн захиргааны байгууллагуудыг оролцуулан 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр цахим уулзалт зохион байгуулж, багш нарын заах арга зүй, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах, Монгол хэл бичиг, соёл, монгол ахуйн уламжлалт зан заншилд суралцах, сургуулиудыг ном, сурах бичгээр хангах, сургалтын контентууд бэлтгэн нийлүүлэх, сургууль, цэцэрлэг, хэл соёлын төвүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлаар санал солилцож, уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.
- Хүүхдүүдэд мэргэжлийн түвшний, чанарын стандарт хангасан мэдлэг эзэмшүүлэх шаардлагатай тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран багшийн мэргэжил, заах арга зүйн цуврал цахим сургалтыг энэ оны 3 дугаар сараас эхлэн тогтмолжуулаад байна. Сургалтад 80 гаруй багш хамрагдаж байна.
- Сургалтын материал бэлтгэх ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран цахим сургалтын материал бэлтгэж, дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан холбогдох сургуулиудад хүргүүлсэн бөгөөд туршилтын тодорхой

хугацааны дараа хэрэглэгчийн санал хүсэлтийг хүлээн авч, сургалтын материалыг улам төгөлдөржүүлэхээр зорьж байна.

- Сурах бичиг хүргүүлэх ажлын хүрээнд Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Шинжлэх ухааны академийн Хэл, зохиолын хүрээлэнтэй хамтран “Хүүхдийн эх хэлний боловсролд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Мал аж ахуйн соёл, Би Монгол хүн, Монгол ярианы сурах бичиг, Монгол хэлний дүймин заах арга зүйн эмхэтгэл зэрэг 350 гаруй номыг холбогдох дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан хүргүүлсэн.
- Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоол, “Дэлхийн Монголчууд-II” гадаад сурталчилгааны цогц арга хэмжээний 2.3.6-д “хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, монголчуудын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээний арга хэмжээг хамтран зохион байгуулна” гэж заасны дагуу “Монголын бүх ард түмний XV наадам”, “Монгол Үндэсний спортын VII наадам”-ын бүсийн тэмцээнийг Монгол Улсаас АНУ, БНФранцУ, БНСолонгосУ-д суугаа Элчин сайдын яамдтай хамтран зохион байгуулж байна.
- Хилийн чанадад оршин сууж байгаа 75 монгол иргэнд “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одон олгох ажлыг дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан зохион байгууллаа.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хилийн чанад дахь Монголчуудын нэгдсэн чуулга уулзалт”-ыг 2022 оны 7 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, холбогдох бэлтгэлийг хангаж байна.

“Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлуудын үр дүнд үндэслэн хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй багш нарт тавигдах мэргэжлийн стандарттай болох, багшлах эрхийг баталгаажуулсан баримт бичиг, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох, гадаад улс оронд монгол хэл сурах орчныг бүрдүүлж, сурагчдыг идэвхжүүлэх, хүүхдүүдэд зориулсан хүүхдийн нэвтрүүлэг, контент, хөтөлбөрүүдийг бэлтгэх, түгээх зэрэг ажлуудыг төлөвлөж, холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

#### *Монгол судлалын чиглэлээр:*

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт Монгол судлалын чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын үндсийг тодорхойлсноос гадна дээрх 2 цогц арга хэмжээнд Монгол судлалыг хөгжүүлэх, Монгол судлалын хүрээг тэлж, дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаалах зорилтуудыг дэвшүүлсэн.

Олон улсад Монгол судлал өргөжин хөгжихийг дэмжиж, гадаадад Монгол судлалын төв байгуулах, Монгол Улсад дэлхийн Монгол судлалын төв байгуулах хүрээнд хөтөлбөр, арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж ирсэн бөгөөд Монгол судлалын чиглэлээр ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг шинэчлэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

Монгол судлалыг хөгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

- “Алсын хараа-2050” болон бодлогын бусад баримт бичигт тулгуурлан ирэх 5 жилд хэрэгжүүлэх Монгол судлалын бодлого, стратегийн баримт бичгийг гаргах;

- Хилийн чанадад “Монгол судлалын төв” болон “Монголын соёлын төв” шинээр байгуулах асуудлыг судалж, холбогдох зардлыг шийдвэрлүүлэх;
- Залуу монгол судлаачдыг олон улсад дэмжих, залуу халааг бэлтгэхэд тусгайлан анхаарч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг олгох, Ерөнхийлөгчийн ивээл дор зуны сургалт зохион байгуулах ажлыг сэргээх, тогтмолжуулах;
- “Дэлхийн монгол судлалын өдөр”-тэй болох асуудлыг шийдвэрлүүлэх, ЮНЕСКО-д бүртгүүлэх ажлыг эхлүүлэх;
- Их Эзэн Чингис хаан мэндэлсний 860 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан энэ оны 8 дугаар сард Чингис хаан судлалын чиглэлээр олон улсын хурлыг зохион байгуулах<sup>3</sup> зэрэг болно.

Өнөөдрийн байдлаар дэлхийн 20 оронд Монгол судлалын 22 төв, 600 гаруй судлаач ажиллаж байгаагаас 200 орчим нь залуу судлаач байна. 2021 онд цар тахлын амаргүй нөхцөлд хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрууд дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 13 улсад 30 гаруй хурал, семинар, лекц зохион байгуулсан.

Дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаалах зорилтын хүрээнд “Чингис хаан” музейн бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлж, музейн сан хөмрөгийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд гадаадын зарим улсаас монгол хаадын түүхэнд хамаарах онцлог үзмэрүүдийг хуулбарлан авах ажлыг зохион байгуулж, дэлхийн 9 улсаас 29 үзмэрийн “А” болон дижитал хуулбарыг авч, музейд хүлээлгэн өгсөн бөгөөд 6 улсаас 44 дан болон иж бүрдэл үзмэрийн хуулбарыг авахаар яриа хэлэлцээг үргэлжлүүлж байна. Үүнээс ОХУ-ын Эрмитажийн цуглуулгаас хамгийн олон буюу 28 дан болон иж бүрдэл үзмэрийг музейн сан хөмрөгт хуулбарлан авах бөгөөд гадаадаас хүлээн авах содон үзмэрт тухайлбал Монголын Юань гүрний усан онгоцны загварын “А” хуулбар багтаж байна.

Соёлын дипломат харилцааг Соёлын элчээр дамжуулан хэрэгжүүлж байна. Энэхүү ардын дипломатын арга нь урт хугацааны туршид, тасралтгүй, тууштай хэрэгжүүлэх зөөлөн хүчний бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ чиглэлээр Соёлын элч нарын үйл ажиллагааг төрийн бодлоготой уялдуулах, олон нийтэд сурталчлах, эрх зүйн орчныг нь сайжруулах, дипломат шугамаар дэмжлэг үзүүлэх, гадаад сурталчилгаа болон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад оролцоог нь нэмэгдүүлэхэд анхаарч, “Соёлын элчийн журам”-ыг шинэчлэн боловсруулахаар бэлтгэж байна. Өнөөдөр дэлхийн 19 оронд 50 соёлын элч томилон ажиллуулж байна.

Монгол Улс Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа заасны дагуу олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Монгол Улсын төр засгаас хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, түүний хэрэгжилт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, урлаг, спортын салбарт болж байгаа чухал үйл явдлуудын тухай бодит мэдээ, мэдээллийг гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж, сурталчлан

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газар “Монгол судлалын үндэсний хөтөлбөр”-ийг 2012-2016 болон 2018-2021 онд хэрэгжүүлсэн ба 2022 оны 3 дугаар сард Үндэсний хэлэлцүүлэг, 4 дүгээр сард Монгол судлалын Үндэсний зөвлөлийн хурлыг хийж, Монгол судлалын чиглэлээр ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг боловсруулж гаргахаар тогтсон.

таниулахад ард түмэн хоорондын найрамдал, нөхөрлөлийн бат бэх гүүр болдог сэтгүүлч, сурвалжлагч нар чухал үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсад өнөөдөр Катар улсын “Аль Жазийра”, БНХАУ-ын “Синьхуа”, Жиньминь Жибао сонин, “Хятадын төв радио, телевиз CCTV”, Япон Улсын “Асахи Шимбүн”, “Киодо Цүүшин”, “Фүжи” телевиз, ОХУ-ын “Mongolnow.com”, Англи Улсын “Ройтерс”, ХБНГУ-ын “bne IntelliNews”, БНФУ-ын “Agence France Presse”, АНУ-ын “Ассошиэйтед пресс”, БНСУ-ын “KBS” телевиз зэрэг нийт 13 хэвлэл, мэдээллийн агентлагийн 21 сурвалжлагч, зураглаач байнгын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын Монгол Улсад ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

### **Хоёр. Соёлын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих арга хэмжээний талаар .**

Монгол Улсын Засгийн газраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого” зэрэг урт болон дунд хугацааны баримт бичгүүд, соёлын салбарын хууль эрх, зүйн болон стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор соёлын салбарын тэргүүлэх бодлого, стратегийг

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг цогцлоох;
2. Бүх нийтийн соёлын боловсролыг олгох;
3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэмээн тодорхойлж, үе шаттайгаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээд байна.

Соёлын бодлого бүх шатанд харилцан уялдаатайгаар хэрэгжсэнээр Монгол Улсыг гадаад улсад сурталчлах соёлын харилцаа, хамтын ажиллагаа сайжрах, Монгол Улсын нэр хүнд олон улсад өсөх, өрсөлдөх чадвар нэмэгдэх, улмаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдэх юм.

Соёлын салбарын тэргүүлэх бодлого, стратегиар дамжуулан Монгол Улсыг гадаад улсад сурталчлах, соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд дараах бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

➤ “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг цогцлоох” бодлогын хүрээнд Үндэсний соёл-нэгдмэл үнэт зүйлийн индексийн судалгааг хийсэн бөгөөд судалгаагаар үндэсний нэгдмэл байдлын түвшин улсын хэмжээнд 49 хувь байна гэж иргэд дүгнэсэн. Үүнийг үндэсний нэгдмэл үнэт зүйлийн 4 бүрэлдэхүүн хүчин зүйлс болох соёлын нэгдмэл байдал (64 хувь), нийгмийн нэгдмэл байдал (52 хувь), улс төрийн нэгдмэл байдал (38 хувь), эдийн засгийн нэгдмэл байдал (40 хувь)-аар нь авч үзэхэд соёлын нэгдмэл байдал хамгийн өндөр үнэлгээтэй байгаа нь үндэстнийг өв соёл, үнэт зүйл нь илүү нэгтгэж байгааг илтгэж байна.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл, түүний засаглалын зарчмууд нь соёлын олон талт байдал, үндэс угсаа, шашин шүтлэгийн нэгдмэл ойлголтод тулгуурлан үндэстний нэгдмэл, нийтлэг сайн сайханд хүрэхэд чиглэсэн үндэсний хэмжээний ашиг сонирхлыг илэрхийлэхэд оршдог бөгөөд дээрх судалгаанд үндэслэн олон улс дахь монголчуудын үнэт зүйл буюу үндэсний нэгдмэл үнэт зүйл, үндэсний ижилсэл, ондоошил, үндэсний брэндингийн бодлого, стратегийг тодорхойлоод байна.



Стратегийг хэрэгжүүлснээр Монголчууд өнгөрсөнд хэн байсан, одоо хэн болсныг харьцуулан судалж, үнэт зүйлсээ бэхжүүлэх, сул талаа хүлээн зөвшөөрч, давуу талаа тодотгон, ирээдүйгээ бататгах замаар соёлын дархлаагаа сайжруулах, дэлхийн бусад улс орон, олон улсын хамтын нийгэмлэгт оруулах Монгол Улсын хувь нэмэр, үнэ цэнийг тодорхойлон батжуулах, улмаар олон улс дахь нэр хүнд өсөх, өрсөлдөх чадвар сайжрах, экспорт нэмэгдэж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

➤ Үндэсний соёлын нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэхэд бүх нийтийг соён гэгээрүүлэх, соёлын боловсрол олгох, оюун санааны дархлааг бэхжүүлэх явдал нэн чухал учир үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай бүтээлч монгол хүнийг бэлтгэх сургалтын тогтолцоог бий болгох зорилгоор “Бүх нийтийн соёлын боловсрол олгох” бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэхээр холбогдох суурь судалгааг хийж байна.

Тус бодлого, стратеги хэрэгжиж эхэлснээр хилийн чанад дахь монгол хэл, соёлын сургалтын төвүүдтэй хамтран албан болон албан бус боловсролын хөтөлбөрөөр дамжуулан гадаадад амьдарч, ажиллаж, сурч байгаа монгол хүүхэд, залуучуудын хэл, соёлын боловсролыг дэмжих, монгол хэл, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх нөхцөл бүрдэх юм.

“Бүх нийтийн соёлын боловсрол”-ын бодлогын хүрээнд үндэсний хэл бичиг, соёлоороо бахархдаг, түгээн дэлгэрүүлж, уламжлал, шинэчлэлийг хослуулан авч явдаг иргэд, хүүхэд залуусыг бий болгох, энэ чиглэлээр үндэсний бичгийн мэдлэгээ өөрийн боломжит цаг үедээ цахимаар дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий “Хос бичигтэн” анхан шатны 18 цагийн цахим сургалтын контент бүтээж, уг контентыг дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан түгээхэд бэлэн болоод байна.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2022 оны 7 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Хилийн чанад дахь Монголчуудын нэгдсэн чуулга уулзалт”-аар хилийн чанад дахь иргэдийн хэл, соёл болон олон улс дахь монголчуудын үнэт зүйлийн талаарх соёлын салбарын бодлого, стратегийг танилцуулахаар төлөвлөж байна.

➤ “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” бодлого, стратегийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хуралдаанд “Монгол соёл, Монголын баялаг” стратеги төлөвлөгөөг танилцуулсан бөгөөд уг стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээг тодорхойлох, ойлголтыг нэгтгэх зорилго бүхий Соёлын бүтээлч эдийн засгийн суурь судалгааг хийж, Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах дараах 12 салбарыг тодорхойлсон. Үүнд:

1. Соёлын өв (биет ба биет бус);
2. Утга зохиол ном хэвлэл;
3. Дүрслэх урлаг, гар урлал;
4. Дуу хөгжим;
5. Тайзны урлаг;
6. Кино, дуу дүрсний урлаг;
7. Хэвлэл мэдээлэл (телевиз, радио, мэдээ);
8. Хувцас загвар, нэхмэл, сүлжмэл;
9. Архитектур;
10. Дизайн (бүтээгдэхүүн, үйлчилгээ);
11. Дижитал контент үйлдвэрлэл (тоглоом, сонирхол татах технологи);
12. Маркетинг, брэндинг, зар сурталчилгаа, харилцаа холбоо (медиа контент).

Судалгаагаар соёлын бүтээлч үйлдвэрлэл нь хөрөнгө оруулалтыг татах замаар ажлын байр, нэмүү өртгийг бий болгох, улс орныг сурталчлах, улс үндэстний өвөрмөц байдал, оюуны дархлааг тодорхойлж, "зөөлөн хүч"-ний бодлого болохоос гадна соёлын контентоор дамжуулан мэдээллийг иргэдэд хүртээмжтэйгээр түгээх замаар тэдний итгэл үнэмшлийг бий болгож, соёлын олон талт байдлыг сурталчлан, хүн ардыг соён гэгээрүүлэх, оюуны дархлааг бий болгох зэрэг нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой болохыг тодорхойлсон.

Дэлхийн өнцөг булан бүрд улс орнууд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих төрөл бүрийн бодлогыг санаачлан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өлгий нутаг болохыг эрмэлзэж байна. Тэр дундаа дуу-дүрсний салбар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамгийн ашигтай салбарт тооцогдож, цар тахлын дараах эдийн засгийг сэргээх гол салбараар нэрлэгдэх болсон. ЮНЕСКО-с гаргасан 2018 оны тайланд дэлхий нийт соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбараас жил бүр 2.2 их наяд ам.долларын орлого олж, 30 сая орчим хүнийг ажлын байраар ханган, ойрын хугацаанд дэлхийн ДНБ-ий 10 хувийг бүрдүүлэх талаар дурдсан байна.

Монгол Улсын соёл, урлагийн салбар 2015-2020 онд ДНБ-д тогтмол 0.4 хувийг бүрдүүлж, үндэсний тооцооны системийн эдийн засгийн үйл ажиллагааны 19 салбарын хамгийн сүүлд эрэмбэлэгдсээр ирсэн. 2015-2020 оны хугацаанд соёл, урлагийн салбар нийт 698.5 тэрбум төгрөгийг ДНБ-д оруулсан нь мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2020 онд дангаараа ДНБ-д оруулсан жилийн орлогод ч хүрэхгүй байна.

Монгол Улсын Засгийн газраас соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэмжлэгийг бий болгож, олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх замаар олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох зорилгоор Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт баримтлах бодлого, хөгжлийн зураглалыг боловсруулаад байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, стратеги хэрэгжиж эхэлснээр Монгол хүний шавхагдашгүй баялаг оюуны бүтээлийг Монгол брэнд болгон дэлхийн зах зээлд нэвтрүүлж, Монгол Улсыг гадаад улсад сурталчлах, соёлын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх бодит нөхцөл бүрдэх юм.

Соёлын салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэмжлэгийг бий болгох зорилгоор Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кино урлагийг дэмжих тухай, Музейн тухай хуулиудыг Улсын Их Хурлаар батлуулсан. Эдгээр хуульд соёлын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлийг олон улсад сурталчлах, соёл, урлагийн олон улсын уралдаан, наадам, үзэсгэлэнд уран бүтээлчдийг оролцуулах талаар тусгаснаас гадна Монгол киног дэлхийн түвшинд гаргах, олон улсын зах зээлд өрсөлдүүлэх, кино үйлдвэрлэлийг дэмжиж эдийн засгийн эргэлтэд оруулах, Монгол Улсад кино бүтээх таатай орчныг бий болгох зорилгоор кино үйлдвэрлэлийн эрх зүйн үндсийг бүрдүүлээд байна.

Шинээр батлагдсан хуулийг дагалдан гарах, эрх зүйн актыг боловсруулах хүрээнд "Соёлын элчийн ажиллах журам", "Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын үнэт зүйлийг таниулахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ", "Гадаадын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх

зөвшөөрөл авах журам” зэрэг холбогдох баримт бичгийг боловсруулж, батлуулах ажлыг эхлүүлээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Монгол Улсыг гадаадад нэг цонх, нэг брэндигээр таниулан сурталчлах, аялал жуулчлал болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлахаар ажиллаж байна. Төлөвлөгөөнд үндэсний нэгдмэл үнэт зүйл, үндэсний брэндийн судалгаанд үндэслэн Монгол Улсыг дэлхийд төлөөлөх соёлын бүтээгдэхүүн бий болгох, Монгол Улс олон улсад ямар байдлаар харагдаж, жуулчдыг хэрхэн татах зэрэг үндэсний хэмжээний аялал жуулчлалын бодлогын үндсэн суурийг бүрдүүлэх, өөрсдийн өв соёл, нүүдлийн зан заншилд тулгуурласан соёлын аялал жуулчлал болон ижил агуулга бүхий сурталчилгаа, соёлын дурсгалт зүйл, аялал жуулчлалын төв зэргийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулах замаар аялал жуулчлалын салбарт оролцогч байгууллагуудтай хамтран ажиллахаар тусгаад байна.

Түүнчлэн Монгол Улсын дүрслэх урлаг болон кино урлагийн уран бүтээлчдийн оюуны бүтээлийг олон улсад таниулан сурталчлах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Олон улсын тэргүүлэх зэрэглэлийн наадамд оролцох тухай” Засгийн газрын 2022 оны 73 дугаар тогтоол гарч, БНИталиУ-д зохион байгуулагддаг Венецийн дүрслэх урлагийн олон улсын биенналь, БНФранцУ-д зохион байгуулагддаг Каннын кино наадамд Монголын уран бүтээлчид оролцох боломжийг бүрдүүлсэн нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх чухал алхам болсон гэж Монгол Улсын Засгийн газар үзэж байна.

Соёлын яамнаас Монгол Улсын хөгжмийн урлагийн хөгжлийг олон улсад сурталчлан таниулах, соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах замаар олон улсын нэр хүнд бүхий уралдаан, наадамд амжилттай оролцсон уран бүтээлчдийн үнэлэмжийг дээшлүүлэх, олон улсын жишигт хүргэх үе шаттай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Мөн Монгол Улсын соёлын үнэт өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, судалгаа, эрдэм шинжилгээний баазыг бий болгох, олон улсын уралдаан наадамд оролцох, соёлын салбарт хамтран ажиллах чиглэлээр Хятад, Солонгос, Турк, Итали, Унгар, Катар, Кувейт Улсууд болон Швейцарийн хөгжлийн агентлагтай эрх зүйн баримт бичиг байгуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлсээр байна.

-----oOo-----